



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосон илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/16/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Хөвсгөл аймаг 2022 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaatara@audit.gov.mn">erdenebaatara@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegg@audit.gov.mn">erdenechimegg@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



---

## Агуулга

---

1. Хараат бус аудиторын тайлан .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	6
4. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
5. Аудитын илрүүлэлт .....	11
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12



“ТОСОН ИЛЧ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.БЯМБАЦОГТ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2022.03.04 № 01/237  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тосон илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тосон илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

“Корона вируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу 32 хэрэглэгчид 21.3 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс санхүүгийн дэмжлэг авсан байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа Leader программ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн нийцэхгүй байгаагаас борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардлыг зөв хуваарилаагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тосон илч ХХК нь 2021 оны зорилтот түвшний биелэлт 101.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.



**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	68,243,091.82	167,742,249.77
1.1.2	Дансны авлага	20,016,199.00	36,531,077.95
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	5,972,217.95	8,984,407.87
1.1.6	Бараа материал	20,266,300.20	31,435,445.05
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	114,497,808.97	244,693,180.64
1.2.1	Үндсэн хөрөнгө	192,372,329.29	166,463,680.23
1.2.2	Биет бус хөрөнгө	13,572,000.00	13,572,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	205,944,329.29	180,035,680.23
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>320,442,138.26</b>	<b>424,728,860.86</b>
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	4,081,747.99	997,573.61
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	156,818.00	156,818.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,238,566.01	1,154,391.62
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,238,566.01</b>	<b>1,154,391.62</b>
2.3.1	Өмч: - төрийн	249,127,532.91	249,127,532.91
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,913,603.18	14,913,603.18
2.3.9	Хуримтлагдсан ашиг	52,162,436.16	159,533,333.15
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>316,203,572.25</b>	<b>423,574,469.24</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>320,442,138.26</b>	<b>424,728,860.86</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	538,392,732.18	590,609,114.87
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	357,179,010.94	390,164,251.44
3	Нийт ашиг (алдагдал)	181,213,721.24	200,444,863.43
8	Бусад орлого	3,843,604.00	343,600.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	73,813,300.35	77,764,901.06
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(8,488,866.83)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	111,244,024.89	114,534,695.54
19	Орлогын татварын зардал	11,124,402.48	11,453,469.55
20	Татварын дараах ашиг (алдагдал)	100,119,622.41	103,081,225.99
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	100,119,622.41	103,081,225.99
23	Бусад дэлгэрэнгүй орлого	33,850,985.00	14,289,671.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	14,289,671.00
	Бусад олз (гарз)	33,850,985.00	0.00
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>133,970,607.41</b>	<b>117,370,896.99</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	235,555,532.91	0.00	0.00	235,555,532.91

Залруулсан үлдэгдэл	13,572,000.00	0.00	0.00	13,572,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	14,913,603.18	52,162,436.16	67,076,039.34
<b>2021 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	<b>249,127,532.91</b>	<b>14,913,603.18</b>	<b>52,162,436.16</b>	<b>316,203,572.25</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	117,370,896.99	117,370,896.99
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	(10,000,000.00)	(10,000,000.00)
<b>2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	<b>249,127,532.91</b>	<b>14,913,603.18</b>	<b>159,533,333.15</b>	<b>423,574,469.24</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>582,589,975.00</b>	<b>631,014,747.41</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	582,589,975.00	630,776,747.41
	Бусад мөнгөн орлого	0.00	238,000.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>450,894,292.10</b>	<b>506,802,269.46</b>
	Ажиллагчдад төлсөн	160,491,494.28	183,523,726.96
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	27,061,555.00	26,542,244.16
	Бараа материал худалдан авахад төлсөн	112,806,146.30	117,478,235.00
	Ашиглалтын зардалд төлсөн	40,436,374.97	44,870,951.18
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,839,167.00	64,790,603.30
	Татварын байгууллагад төлсөн	39,465,524.55	58,514,613.86
	Бусад мөнгөн зарлага	12,794,030.00	11,081,895.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>131,695,682.90</b>	<b>124,212,477.95</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	73,869,800.00	14,713,320.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	73,869,800.00	14,713,320.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,295,000.00)	(14,713,320.00)
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,000,000.00	10,000,000.00
	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	10,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,000,000.00)	(10,000,000.00)
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>47,825,882.90</b>	<b>99,499,157.95</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>20,417,208.92</b>	<b>68,243,091.82</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>68,243,091.82</b>	<b>167,742,249.77</b>

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Тосон илч ХХК ба түүний үйл ажиллагаа

Тосон илч ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймаг, Тосонцэнгэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Компани нь 2011 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор Их-Уул дулаан ХХК болон өөрчлөгдсөн.

Компани нь нийт 2 ажилтантай, Төлөөлөн удирдах зөвлөлийн 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан үйлдвэрлэх, түгээх
- Цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах

#### 3.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Тосон илч ХХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн нийцээгүй байна.

Компани нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагдах аргаар бүртгэж тайлагнадаг.

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй байна.

Тухайлбал: Өртөг, зардлын хуваарилалтыг бүрэн хийх боломжгүй, гар ажиллагаа ихтэй байна.

#### 3.4 Зорилтот түвшин, төлөвлөгөө, гүйцэтгэл

Компанийн гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Тосон илч ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7 дугаар тогтоолоор бизнес төлөвлөгөөнд нийт орлогыг 575.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 565.4 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 1.0 сая төгрөгөөр баталсан байна.

Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний 14 дүгээр тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас 10.0 сая төгрөгийг Тосонцэнгэл сумын орон нутгийн төсөвт ногдол ашиг төлөхөөр шийдвэрлэн төлсөн байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 590.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 476.4 сая төгрөгийн зардал гарган, 114.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Д.Д	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021		/сая төгрөг/ Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2021 гүйц-2021 төл	Хувиар
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	542.20	<b>575.4</b>	<b>590.6</b>	<b>15.2</b>	<b>102.6</b>
	Халаалтын орлого	506.1	555.7	561	<b>5.3</b>	<b>101.0</b>
	Цэвэр борхир усны орлого	3.8	8.4	19.3	<b>10.9</b>	<b>229.8</b>
	Бусад	32.3	11.3	10.3	<b>-1.0</b>	<b>91.2</b>
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>542.20</b>	<b>575.4</b>	<b>590.6</b>	<b>15.2</b>	<b>102.6</b>
3	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>431.00</b>	<b>565.4</b>	<b>476.4</b>	<b>-89</b>	<b>84.3</b>
	Үүнээс:ББӨ	357.20	485.4	390.2	<b>-95.2</b>	<b>80.4</b>
	Удирдлагын зардал	73.80	80	77.8	<b>-2.2</b>	<b>97.3</b>
	Бусад			8.4	<b>8.4</b>	
4	Татварын өмнөх ашиг	111.20	10	114.5	<b>104.5</b>	
	Татварын зардал	11.1	1	11.4	<b>10.4</b>	
5	Цэвэр ашиг /алдагдал/	100.10	9	103.1	<b>94.1</b>	
8	Нийт ажиллагсдын тоо	23	23	23	<b>0</b>	<b>100.0</b>
9	Нийт цалингийн сан	46.4	201.7	185.3	<b>-16.4</b>	<b>91.9</b>
13	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	0.79	0.98	0.81	<b>-0.17</b>	<b>82.7</b>
15	<b>НИЙТ АВЛАГА</b>	<b>25.90</b>	<b>0</b>	<b>8.9</b>	<b>8.9</b>	
16	<b>НИЙТ ӨГЛӨГ</b>	<b>4.20</b>	<b>0</b>	<b>1.1</b>	<b>1.1</b>	
	Үүнээс: Богино хугацаат	4.2		1.1	1.10	

Тайлант онд орлогын төлөвлөгөөг 15.2 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар, зардлын төлөвлөгөөг 89.0 сая төгрөгөөр хэмнэж үр ашигтай ажилласан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5 Тосон илч ХХК-ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Их-Уул дулаан ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34.2 сая төгрөгөөр буюу 6.5 хувиар өсөж 564.4 сая төгрөг болсон байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	68.2	167.7	99.5
Авлага	26.0	45.5	16.5
Бараа материал	20.3	31.4	11.1
Үндсэн хөрөнгө	192.4	166.5	-25.9

Биет бус хөрөнгө	13.6	13.6	0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>320.4</b>	<b>424.7</b>	<b>104.3</b>
Өр төлбөр	4.2	1.1	-3.1
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	316.2	423.6	107.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>320.4</b>	<b>424.7</b>	<b>104.3</b>

Тайлант онд мөнгөн хөрөнгө өмнөх оноос 99.5 сая төгрөгөөр өсөж 167.7 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Дансны авлага өмнөх оноос 16,5 сая төгрөгөөр нэмэгдэж 36.5 сая төгрөг байгаа нь НӨАТ-ийн авлага 8.9 сая төгрөг, тооцооны авлага 36.5 сая төгрөг байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 25.9 сая төгрөгөөр буурсан нь АИТХ-ын тогтоолоор 94.4 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хасаж, 14.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэлж орлого болгосон, төлөвлөгөөнд туссаны дагуу 14.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 45.1 сая төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Тус компанийн ашигт ажиллагаа дээшилж, төлбөрийн чадвар эерэг байна гэж үзлээ.

### 3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд гүйцэтгэх захирлыг томилгоо, шаардлага зардал гаргах, хөрөнгө хүлээн авах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний гүйцэтгэл санхүүгийн тайлангийн аудит, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг 5.0 сая төгрөг байхаар ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг үйл ажиллагаа явуулах 8 сараар тооцон олгохоор баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшуулалд 4.2 сая төгрөг, бусад зардалд 0.8 сая төгрөг зарцуулсан байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосон илч ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардлын данстай холбоотой, гэрээ хэлцлийн талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тосон илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Тосон илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 468.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 678.7 сая төгрөгийн 99 мэдээллээс 11.0 сая төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.10. “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” заалттай нийцэхгүй байна.

байна.

Шийдвэрлэсэн нь:

##### **4.5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулсан Тэнгэрийн шугам ХХК-тай хийсэн нүүрс тээврийн гэрээ нь хэт ерөнхий бөгөөд гэрээний бусад шаардлагатай баримт бичиг /гэрээний үнийн санал, тусгай нөхцөл, ерөнхий нөхцөл, техникийн тодорхойлолт,

хуваарь, санхүүжилтийн хуваарь/ хавсрагдаагүй, гэрээ хийсэн огноогүй байна. Энэ нь Сангийн Сайдын 2021 оны 145 дугаар тушаалаар баталсан "Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт"-ийн VI бүлэгт заасантай нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тосон илч ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй, өмнөх аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Зардлын хуваарилалтыг санхүүгийн программ хангамжид үнэн зөв хуваарилсан эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй.

### **5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 11.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Тосон илч ХХК-ийн санхүүгийн тайланд алдаа залруулаагүй, залруулагдаагүй алдаагүй болно.

#### **4.2 Төлбөрийн акт**

Тосон илч ХХК-ийн санхүүгийн тайланд төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### **4.3 Албан шаардлага**

Тосон илч ХХК-ийн санхүүгийн тайланд албан шаардлага өгөөгүй болно.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тосон илч ХХК-ийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Тухайлбал: Хөрөнгийн өртөгт тээвэр, бэлтгэл, хөгжүүлэлтийн зардлыг шингээх, капиталжуулах, зардлыг өртгийг борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардалд хэрхэн хуваарилах талаар тусгаагүй, санхүүгийн программ гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2."Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалт болон нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программыг үйлдвэрлэл эрхэлж буй онцлогтойгоо уялдуулж өөрчлөлт оруулах.

##### **2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 11.0 сая төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар; заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

### 3. Гэрээ, хэлцэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулсан Тэнгэрийн шугам ХХК-тай хийсэн нүүрс тээврийн гэрээ нь хэт ерөнхий бөгөөд гэрээний бусад шаардлагатай барим бичиг /гэрээний үнийн санал, тусгай нөхцөл, ерөнхий нөхцөл, техникийн тодорхойлолт, хуваарь, санхүүжилтийн хуваарь/ хавсрагдаагүй, гэрээ хийсэн огноогүй байна. Энэ нь Сангийн Сайдын 2021 оны 145 дугаар тушаалаар баталсан "Ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт"-ийн VI бүлэгт заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон өөрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ, хэлэлцээ хийхдээ "Гэрээ"-нд шаардлагатай хавсралт мэдээллийг бүрэн бүрдүүлж хэрэгжилтийг тооцон ажиллах байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1.	Тосон илч ХХК	1								1	
Дүн											
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2.	Тосон илч ХХК	2	11.0							2	11.0
Дүн											
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>11.0</b>							<b>3</b>	<b>11.0</b>

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ

Б.ТЭГШДЭЛГЭР

А.ЭРДЭНЭБААТАР

1720090001-3:0070605